



БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,  
СПОРТЫН ЯАМ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД УХНААГИЙН ХҮРЭЛСҮХИЙН ИВЭЭЛ ДОР  
“ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ - ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛ”  
УЛСЫН ХОЁРДУГААР ЗӨВЛӨГӨӨН - 2018



# ҮР ДҮНД СУУРИЛСАН ЦАЛИН ХӨЛСНИЙ ШИНЭЧЛЭЛ

Илтгэгч: Ж.Ганбаатар (БСШУСЯ)



# БҮТЭЦ

- Цалин хөлсний талаарх хууль эрх зүйн зохицуулалт
- Цалин хөлсний тогтолцооны өнөөгийн байдал
- Үр дүнд суурилсан цалин хөлсний тогтолцоо



# Цалин хөлсний талаарх хууль, эрх зүйн зохицуулалт

Хөдөлмөрийн тухай хууль,  
4 дүгээр бүлэг,  
47-69 дүгээр зүйл

Цалин хөлс, түүний зохицуулалт, олгох зарчим, хэлбэр, хугацаа, суутгал, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, олговор

Төрийн албаны тухай хууль  
28 дугаар зүйл

Төрийн албан хаагчийн цалин хөлс

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хууль

Хөдөлмөрийн гэрээ болон хөлсөөр ажиллах гэрээ, тэдгээртэй адилтгах бусад гэрээнд баримтлах цагийн үндсэн цалин/хөлс/-гийн доод хэмжээг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулж байна.



# Цалин хөлсний талаарх хууль, эрх зүйн зохицуулалт

Цалин хөлсний талаар үндэсний хэмжээнд баримтлах бодлого

- Төрийн болон хувийн хэвшилд ажиллагчдын цалин хөлсний тогтолцоо, зохицуулалтын механизмыг бүрдүүлэх хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох
- Үндэсний болон бүс нутаг, салбарын түвшинд тарифын хэлэлцээрээр цалин хөлсний зохистой тогтолцоог бүрдүүлэх нийгмийн түншлэлийг төлөвшүүлж хөгжүүлэх
- ААНБ-ын түвшинд хамтын гэрээ, хэлэлцээрээр цалин хөлсний тогтолцоо бий болгох нийгмийн түншлэлийг дэмжих
- Цалин хөлсний талаарх судалгаа, мэдээллийг сайжруулж, хүртээмжийг нэмэгдүүлэх

Журам, заавар, аргачлал

- Дундаж цалин хөлс тодорхойлох, Ажлын цагийг нэгтгэн бодох, Ээлжийн амралтын олговор тооцох журам
- Ээлжийн амралт олгох заавар
- Ажлын байрыг үнэлэх, ажил мэргэжлийг бүлэглэх, зэрэглэх аргачлал
- Хөдөлмөрийн бүтээмж тооцох аргачлал
- Хөдөлмөрийн норм, норматив тогтоох аргачлал
- Аж ахуйн нэгж, байгууллагад цалин хөлсний талаар баримтлах зөвлөмж гэх мэт



# Цалин хөлсний талаарх хууль, эрх зүйн зохицуулалт

## Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр

1.13. Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулах эрх зүйн орчин бүрдүүлнэ.

3.1.19. Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудын ажлын ачааллыг тооцож, норм, нормативтай болгон илүү цагийн хөлсийг тухай бүрд нь тооцож олгодог болно.

3.2.55. Соёл, шинжлэх ухааны салбарын ажиллагчдын хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлнэ.

3.3.11. Багш, эмч, эмнэлгийн ажилтнуудын ажлын ачаалал, ур чадвар, мэргэшил, ажлын үр дүн, ажилласан жил зэргээс хамаарсан цалин хөлс, урамшууллын тогтолцоог бий болгоно.

3.3.23. Тэтгэвэр, тэтгэмж, цалинг үе шаттай нэмэгдүүлнэ.



# Цалин хөлсний тогтолцооны өнөөгийн байдал

- Хөдөлмөрийн тухай хууль, Цалин хөлстэй холбоотой журам, заавар, аргачлалууд
- “Тариф, мэргэжлийн лавлах зохиох аргачлал”-ын дагуу боловсруулсан цалингийн сүлжээ.
- Ажлын байрны үнэлгээ нь онооны системд суурилсан

## Ажлын байрны үнэлгээний хүчин зүйлүүд:

➤ Ажлын процессийн үүрэг	72.0%
➤ Ажилд бэлтгэх үүрэг	9.3%
➤ Тооцооны үүрэг	5.3%
➤ Тоног төхөөрөмж ажиллуулах үүрэг	5.3%
➤ Хариуцлага	8.1%
	100%



# Цалин хөлсний тогтолцооны өнөөгийн байдал

Боловсролын салбар төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэл /ЗГ-ын 2007 оны 354 дүгээр тогтоол/

Албан тушаалын ангилал	Тухайн ангилалд хамаарах албан тушаалын товч тодорхойлолт	Зэрэглэл	Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагуудын төрийн үйлчилгээний албан тушаал
1	2	3	4
Удирдах албан хаагч	Төрийн үйлчилгээний бие даасан байгууллагыг удирдаж, эрх хэмжээнийхээ хүрээнд шийдвэр гаргадаг албан тушаал	ТҮБД-8	• Ерөнхий боловсролын цогцолбор сургуулийн захирал
		ТҮБД-7	• Ерөнхий боловсролын сургуулийн захирал • Ерөнхий боловсролын цогцолбор сургуулийн сургалтын ерөнхий менежер
		ТҮБД-6	• Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын менежер • Цэцэрлэг, яслийн эрхлэгч
Мэргэжлийн албан хаагч	Тодорхой нарийн мэргэжил, авъяас, ур чадвар, туршлага шаардах ажил эрхэлдэг, тухайн мэргэжлээрээ бие даан ажилладаг буюу удирдлагын шийдвэр гаргахад шаардагдах санал, зөвлөмж гаргах үүрэг бүхий албан тушаал	ТҮБД-5	• Ерөнхий боловсролын тусгай сургуулийн арга зүйч
		ТҮБД-4	• Ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтан • Ерөнхий боловсролын сургуулийн багш • Цэцэрлэг, яслийн арга зүйч • Цэцэрлэг, яслийн багш
		ТҮБД-3	• Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны багш • Ерөнхий боловсролын тусгай сургуулийн эрдэм шинжилгээний ажилтан
		ТҮБД-2	• Хичээлийн зохицуулагч
Техникийн гүйцэтгэх албан хаагч	Байгууллагын үйл ажиллагаа, зорилтыг биелүүлэхэд тодорхой мэргэжил, боловсрол, ур чадвар шаардах ажил гүйцэтгэх үүрэг бүхий албан тушаал	ТҮБД-1	• Цэцэрлэг, яслийн туслах багш



# Цалин хөлсний өнөөгийн байдал

## Багшийн цалингийн бүтэц:

Цалингийн бүтэц	Нэмэгдэл, нэмэгдэл хөлсний төрөл	Үндсэн цалингаас тооцох хувь хэмжээ
Үндсэн цалин	Засгийн газрын баталсан ТҮБД сүлжээгээр	ТҮБД-4
Нэмэгдэл хөлс	Илүү цагийн хөлс	7 хоногт хичээл заах 19 цагаас илүүг илүү цагаар тооцно
	Анги даасны хөлс	10%
	Кабинет, лаборатори хариуцсаны хөлс	5%
	Заах аргын нэгдэл удирдсаны хөлс	5%
Нэмэгдэл	Мэргэжлийн зэргийн нэмэгдэл	Заах аргач 10%, тэргүүлэх 15%, зөвлөх 20%
	Ур чадварын нэмэгдэл	10%
	Орон нутгийн нэмэгдэл	Аймгийн төв 8%, сум 10%
Улирлын ажлын үр дүнгийн урамшуулал		Багш 20 хүртэл хувь





# Цалин хөлсний шинэчлэлийн бодлого

## Шинэчлэлийн зарчим:

- Багшийн хөдөлмөрийн үнэлэмж, үнэ цэнийг бодитой өргөх;
- Багшийн цалин хөлс нь амьдрал, ахуйн зайлшгүй хэрэгцээг хангадаг байх;
- Багшийн үндсэн цалин нь хөдөлмөрийн онцлог, нөхцөл, ачаалалтай уялдсан, ялгаатай байх;
- Багшийн цалин хөлс нь ажлын үр дүнтэй шууд хамааралтай байх;
- Багшийн ажлын чиг үүрэг, үнэлгээ нь тодорхой байх;
- Багшийн ажлын үнэлгээний зорилго, үнэлэх шалгуур, үзүүлэлт нь хөдөлмөрийн чиг үүрэгт нь нийцтэй байх;
- Багшийн ажлын үнэлгээ нь бодитой, шударга, ил тод, нээлттэй байх.



# Үр дүнд суурилсан цалингийн тогтолцоо

**Багшийн цалин, хөлсний шинэ тогтолцооны эрх зүйн орчинг бий болгох. Ажлын туршлага, ур чадвар, ачаалалд суурилсан, ажлын үр дүн, бүтээмж, чанараар цалинждаг цалин хөлсний шударга, ил тод, нээлттэй, тогтолцоог бүрдүүлэх;**

Сангийн сайд, ХНХ-ын сайд, БСШУС-ын сайдын “Ажлын хэсэг байгуулах тухай” тухай 322/а170/а270 тоот хамтарсан тушаал 2017 онд батлагдлаа.

- Багшийн хөдөлмөрийн нөхцөл, ажлын байрны үнэлгээг хийж, үндсэн цалинг нэмэгдүүлэх, албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэх;
- Багшийн хөдөлмөрийн үнэлэмж, ачааллыг хянан судалж, багшийн ажлын чиг үүргийг шинжлэх ухааны үндэстэй тогтоож, ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэх;
- Цэцэрлэгийн багш, бага ангийн багшийн үндсэн цалинг хөдөлмөрийн онцлог, нөхцөл, ачаалалтай нь уялдуулж ялгаатай тогтоож, үндсэн цалинг нэмэгдүүлэх;
- Багшийн ажлын норм, нормативуудыг хянаж, шинэчлэх;
- Сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч, сургалтын менежер, цэцэрлэгийн арга зүйчийн цалин хөлсийг ажлын чиг үүрэг, ачаалалтай нь уялдуулан шинэчлэх;
- Багшийн цалин хөлсийг мэргэжлийн ур чадвартай нь уялдуулан ялгаатай тогтоох, багшийг мэргэжлээ тасралтгүй дээшлүүлэх нөхцөлийг хангасан мэргэжил дээшлүүлэх үндэсний тогтолцоог бий болгох.



# Үр дүнд суурилсан цалингийн тогтолцоо

## АЖЛЫН БАЙРАНД СУУРИЛСАН ЦАЛИН ХӨЛСНИЙ ТОГТОЛЦОО НЭВТРҮҮЛЭХ:

- Ажлын байрны харьцангуй үнэ цэнийг тодорхойлон үндсэн цалин тогтоох тогтолцоо юм. Ажлын байруудыг хооронд нь харьцуулан дараах үндсэн 4 хүчин зүйлээр ажлын байрыг үнэлнэ.
  - МЭРГЭЖЛИЙН УР ЧАДВАР
  - ХАРИУЦЛАГА
  - АЖЛЫН АЧААЛАЛ
  - ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН НӨХЦӨЛ
- Ажлын байранд суурилсан цалин хөлсний тогтолцоотой улс орнууд: АНУ, Англи, Европын ихэнх орнууд, сүүлийн үед Азийн улс орнуудад нэвтрүүлж эхэлсэн. Ихэнх салбаруудад тохиромжтой. Нийтлэг хэрэглэдэг.



# Үр дүнд суурилсан цалингийн тогтолцоо

## Ажлын байрны үнэлгээний зорилго:

- Нэг ажлыг нөгөө ажилтай харьцуулан оноо өгч харьцангуй үнэ цэнийг тодорхойлох замаар үндсэн цалинг тогтоох
- Адил хөдөлмөрт тэгш шан хөлс олгох тухай ОУХБ-ын 100-р конвенцийн зарчим, үзэл баримтлалд нийцүүлэх /онооны арга/
- Үндсэн цалинг бодитой, шударга тогтоох
- Салбар байгууллагын хэмжээнд цалин хөлсөөр ялгаварлахгүй байх



# Үр дүнд суурилсан цалингийн ТОГТОЛЦОО

## Ажлын байрны үнэлгээ хийх аргачлал:

2018-02-03 сар

Нөхцөл  
байдлын  
судалгаа

2018-04 сар

Ажил, албан  
тушаалын  
жагсаалт,  
ажлын байрны  
ангилал

2018-05-07 сар

Ажлын байрны  
үнэлгээний  
хүчин зүйл  
сонгох, онооны  
хүснэгт гаргах

2018-08 сар

Ажлын байрны  
үнэлгээ,  
үнэлгээний үр  
дүн

2018-09 сар

Салбарын  
хэлэлцүүлэг,  
цалингийн  
зэрэглэлийн  
төсөл хэлэлцэх



# АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА